

ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ДЭХ НЭР ТОМЬЁНЫ АСУУДАЛД

*Э.Батзориг**

Олон улсын гэрээний эрх зүйн салбарт зайлшгүй биелэгдэх хэм хэмжээг үүсгэдэг гэрээ, хэлэлцээр, чартер, статут, конвенци, деклараци, аккорд, протокол, модус вивенди болон ойлголцлын меморандум зэрэг нэр томъёонуудыг ойлголт, чиг үүрэг, хэрэглээнийх нь хувьд цэгцлэж, дүгнэлт хийхэд эл өгүүлийн зорилго оршиж буйг юуны түрүүнд тэмдэглэе.

Гэсэн хэдий ч олон зууны туршид улс гүрнүүд өөр хоорондын эрх, үүргийг тогтоож байсан баримт бичгийн нэрийг өөр өөрөөр нэрлэж байснаас үүдэн “холилдсон” тэдгээрийн тогтсон нэршил, тухайлсан утгыг нэг мөр болгон ойлгоход хүндрэл учруулж байсныг удаахь байрт тэмдэглэе.¹

Манай улсын хувьд, тэр дундаа судлаачид дээрхи нэр томъёоны утга санааг оновчтой болгох, зөв хэрэглээг хэвшүүлэх тал дээр төдийлөн анхаарал тавилгүй ирсэн ба хуулийн их, дээд сургуулиудад заах холбогдох хичээлийн явцад тэдгээрийг цухас дурьдах төдийхнөөр өнгөрч буй нь зохисгүй мэт санагдана.

Нөгөө талаас нэр томъёоны асуудалд ул суурьтай хандаагүйн уршгаар тэдгээрийг хэрхэн нэрийдэх нь дур зоргын асуудал болж байгаа төдийгүй буруу нэрлэснээс болж чухалд тооцогдох олон улсын баримт бичгийн ач холбогдлыг үлэмж бууруулах сөрөг үр дагаварт хүрч болзошгүй юм.²

Олон улсын баримт бичгийг хэрхэн нэрийдэх нь хэлэлцэн тохирох асуудлын шинж, ач холбогдол, улмаар талуудын хүсэл зоригоос ихээхэн хамааралтай юм. Хэдийгээр баримт бичгүүд нь оноосон нэрээрээ өөр хоорондоо ялгагдах боловч тэдгээрт нийтлэг онцлог, олон улсын эрх зүйн түгээмэл зарчмууд үйлчилдэг гэдгийг дурьдах нь зүйтэй. Эл зарчмууд нь улсуудын хоёр талт харилцаанд заавалчгүй мөрдөгдөх хэм хэмжээ болон тогтсон нь заншлын эрх зүй бөгөөд түүнийг төрөлжүүлэн эмхэтгэх үүднээс олон улсын хоёр конвенцийг³ баталсан түүхтэй. Харамсалтай нь 1969 болоод 1986 оны конвенцуудын аль алианаар баримт бичгийн оноосон нэрийн ялгааг гаргаж өгөөгүй юм. Харин тэдгээрт агуулагдах дүрмүүд нь олон улсын бүхий л баримт бичигт хэрэглэгдэж болохыг заажээ.

НҮБ-ын Дүрмийн 102 дугаар зүйлд: “Энэхүү Дүрэм хүчин төгөлдөр болсноос хойш НҮБ-ын аль ч гишүүний байгуулсан аливаа гэрээ болон олон улсын хэлэлцээрийг нарийн бичгийн дарга нарын газарт аль

*Э.Батзориг - МУИС-ийн Хууль зүйн сургуулийн 4 дүгээр дамжааны оюутан

болохоор шуурхай бүртгүүлж, тэндээс хэвлэн нийтлүүлж байвал зохино” хэмээн заасан.⁴ Тэнд “гэрээ”, “олон улсын хэлэлцээр” гэж зааснаараа хууль зүйн дээд хүчин чадал бүхий баримт бичгийг тодотгосон нь сайн хэрэг боловч Ерөнхий Ассемблейн зүгээс дээрхи хоёр нэр томъёонд нарийн тодорхойлолт өгөөгүйгээр барахгүй, тэдгээрийн харилцаа хамаарлыг ойлгомжтой болгох талаар ямар ч арга хэмжээ аваагүй юм.

Уг зүйлийн үр нөлөөг тодорхойлох зорилготой Ерөнхий Ассемблейн Зохицуулалтын 1 дүгээр зүйлд: “Гэрээ болон олон улсын хэлэлцээр нь хэлбэр болон тухайлсан нэрнээсээ үл хамааран заавал бүртгэгдэх ёстой” хэмээн заасныг энд дурьдахад илүүдэхгүй. Практикаас харахад НҮБ-ын Дүрмийн дагуу үүрэг хүлээж НҮБ-д шинээр элсэж буй гишүүн улсаас гаргасан, Олон улсын Шүүхийн Дүрмийн 36 дугаар зүйлийн 2-т заасан шүүхийн шууд харьяаллыг хүлээн зөвшөөрч буйгаа илэрхийлсэн, мөн деклараци гаргагч буюу бусад улсын хооронд заавалчгүй мөрдөгдөх хэм хэмжээ үүсгэж буй нэг талын деклараци зэргийг 102 дугаар зүйлд заасан “гэрээ”, “олон улсын хэлэлцээр” зэрэг баримт бичигт хамааруулан ойлгож болохоор байна.

Оноосон нэр нь тухайн гэрээний зорилт, эсвэл холбогдох асуудлын хүрээнд оролцогч талуудын зүгээс хийх үйл ажиллагааны боломжит хязгаарыг тодотгосон байдаг. Талуудын бодит зорилгыг заримдаа гэрээний зүйл, эсвэл түүний оршлоос мэдэж болох төдийгүй нэр томъёо нь тухайн гэрээг түүний өмнөх эсвэл хойно хийгдэх хэлэлцээртэй харилцан холбоотой эсэхийг тодотгоно.

“Гэрээ, хэлэлцээр байгуулна”, “Холбогдох гэрээ, хэлэлцээр төслийн шатандаа явж байгаа” гэх үгс сонсогдож байдаг. Тэгвэл гэрээ, хэлэлцээр гэдэг нь холбоо үг үү? Тус тусдаа утга илэрхийлэх салангид үг үү?

Юуны өмнө гэрээний эрх зүйн Венийн конвенцид зааснаар⁵ “гэрээ” гэдэг нь ерөнхий утгаараа олон улсын эрх зүйн субъектуудын байгуулсан заавалчгүй мөрдөгдөх шинжтэй бүхий л баримт бичгийг илэрхийлдэг. Тухайн баримт бичиг нь “гэрээ” гэх тодотголыг авахын тулд хэд хэдэн шалгуурыг хангадаг. Юуны түрүүнд гэрээний талууд эрх зүйн эрх, үүргийг тогтоох замаар зайлшгүй биелэгдэх нөхцөл байдлыг үүсгэх, хоёрдугаарт гэрээ байгуулах эрх бүхий улс эсвэл олон улсын байгууллага тухайн баримт бичгийг байгуулах, гуравдугаарт олон улсын эрх зүйн хүрээнд, эцэст нь түүнийг бичгээр⁶ хийсэн байх учиртай.

Ямар баримт бичгийг гэрээ гэж нэрлэх тухай тогтсон практик байхгүй ч улсын оршин тогтнохтой холбоотой зэрэг томоохон асуудлаар хийсэн тохиролцоог гэрээ гэдэг. Тухайлбал Энхийн гэрээ, Хилийн болоод хил тогтоох гэрээ, Шилжүүлэн өгөх гэрээ, Найрамдлын гэрээ, Худалдаа-хамтын ажиллагааны гэрээ гэх мэт.

Хэлэлцээрийг гэрээнээс ялгаж өгөх гол шинж нь олон улсын хэлэлцээр бичгэн бус хэлбэртэй байж болдог явдал юм.⁷ Гэсэн хэдий ч тиймэрхүү аман хэлэлцээрүүд нь гэрээний адилаар талуудын хүсэл зорилгоос хамаарч даган биелэгдэх хүчин чадалтай байдаг. Гэрээнийхийг бодвол хэлэлцээрийн зүйл нь явцуу хүрээний асуудал байдаг тул гол төлөв засгийн газрын харьяа албадын төлөөлөгчид гарын үсэг зурдаг, захиргаа, техникийн шинжтэй хоёр буюу хязгаарлагдмал олон талт тохиролцоог хэлэлцээр гэж нэрлэдэг.

Давхар татвар оногдуулахгүй байх тухай, Хөрөнгө оруулалтын баталгааны тухай, Санхүүгийн дэмжлэг үзүүлэх тухай зэрэг улс хоорондын эдийн засгийн асуудлаар байгуулсан баримт бичгийг хэлэлцээр гэнэ. НҮБ болон бусад ОУБ олон улсын конференц, эсвэл ээлжит чуулганы үеэр зочин улстай хэлэлцээр байгуулна.

Мөн бүсийн⁸ интеграцчлалын схемийн Үндсэн гэрээний хүрээнд, эсвэл бүсийн байгууллагаас байгуулсан баримт бичгийг Үндсэн гэрээнээс нь ялгахын тулд “хэлэлцээр” гэж нэрлэх нь бий. 1957 оны Ромын гэрээ нь Европын Хамтын Нийгэмлэгийн хувьд квази хэлбэрийн үндсэн хууль бол ЕХН-ийн зүгээс бусад улстай байгуулж буй гэрээг хэлэлцээр гэж ойлгоно. Түүнчлэн Монтвидеогийн гэрээг Латин Америкийн Интеграцлалын Холбоог байгуулсан тулгуур эрхийн баримт бичиг гэж үзвэл түүний хүрээнд томъёологдож, хуулийн үйлчлэлд орсон бүсийн дэд баримт бичгийг хэлэлцээр гэж үзнэ.

Бүтэц, зохион байгуулалт, эрх хэмжээ, чиг үүргийг нь харгалзан үзэлгүйгээр үүсгэн байгуулах баримт бичиг л бол түүнийг Дүрэм гэж нэрлэдэг. Гэтэл олон улсын хэмжээнд олон улсын байгууллагыг үүсгэх баримт бичгийг чартер (1945 оны НҮБ-ийн Чартер, 1952 оны АМБ-ын Чартер), харин түүний салбар институт байгуулах баримт бичгийг статут (Европын Төв Банкны Статут) хэмээн ялгавартайгаар хэрэглэдэг. Мөн олон улсын шүүх байгуулах баримт бичгийг статут гэнэ. (Олон улсын Шүүхийн Статут, Олон улсын Эрүүгийн шүүхийн Ромын Статут)

Олон улсын баримт бичгийг хэрхэн нэрлэх нь түүнийг хэн байгуулж байна гэдгээс ихээхэн хамааралтай. Учир нь гол төлөв олон улсын байгууллага,⁹ түүний салбарын¹⁰ ивээл дор “мэндэлж” буй баримт бичгийг конвенци гэдэг. Өнгөрсөн зууны турш конвенци гэдэгт хоёр талт хэлэлцээрийг ойлгож байсан бол өнөө үед өргөн хүрээний оролцогч бүхий олон талт гэрээг дүйн хэрэглэж байна. Конвенци нь түүнд нэгдэн орох асуудлаар олон улсын хамтын нийгэмлэгүүд болон улс гүрнүүдэд үргэлжийн нээлттэй байдаг.

Талууд ямар нэгэн үүрэг үүсгэлгүйгээр тодорхой асуудалд өөрсдийн байр сууриа илэрхийлэх үед декларацийг¹¹ хэрэглэдэг. Гэхдээ деклараци болгон хэм хэмжээ үүсгэдэггүй гэж ойлгож болохгүй.

Өөрөөр хэлбэл зарим декларацийн тодорхой нэгэн заалт нь заншлын хэм хэмжээний нөлөөллийг өөртөө агуулж, тэр нь тодорхой хэмжээгээр үйлчилж байдаг.¹² Заавалчгүй биелэгдэх хэм хэмжээг үүсгэж байдаг декларацийг дараахь байдлаар ангилж болно. Үүнд: (а) Нарийн асуудлаар байгуулсан деклараци,¹³ (б) Тайлбарласан Деклараци,¹⁴ (в) Ач холбогдлоор жин бага дарах асуудлаар байгуулсан албан бус хэлэлцээрийг деклараци гэдэг бол (г) Нэг талын декларацийн цуврал нь заавалчгүй биелэх хэлэлцээрийн үндэс болдог.¹⁵

Ерөнхий утгаараа энхийн тохиролцоог гэрээний категорит оруулах тухай дээр дурьдсан. Тэгвэл тодорхой утгаараа олон улсын практикт Энхийн гэрээг Аккорд¹⁶ хэмээн нэрлэж заншжээ.

Эрэмблэлийн хувьд гэрээ болон конвенциос доогуур, албан бус шинжтэй хэлэлцээрийг протокол гэдэг. Үүнд дараахь төрлийн баримт бичгүүд хамаарна.

- *Гарын Үсгийн Протокол* нь гэрээнд туслах чанарын баримт бичиг болдог. Гэрээний зарим зүйлийг тайлбарлах зэрэг техникийн чанартай асуудал энд хамаарагдана. Ийм төрлийн протоколын жинхэнэ гэрээг соёрхон батлахад л хангалттай.

- *Албан бус Протокол* нь жинхэнэ гэрээнд нэмэлт эрх, үүргийг тогтоож өгөхөд хэрэглэгддэг. Түүнийг заавал тусад нь соёрхон баталдаг онцлогтой. Мөн олон талт гэрээний хувьд оролцогч аль нэг хоёр тал хоорондоо ерөнхий зорилгоос гадуур (гэхдээ түүнд харшлахгүй) нэмэлт үүргийг тогтоох боломжийг албан бус протокол олгодог.¹⁷

- *Үндсэн Гэрээний Протокол* нь өмнөх, эсвэл “тулгуур” конвенцийн гол зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор нэмэлт үүрэг тогтоох замаар үүснэ. Ийм төрлийн протокол нь гэрээ байгуулах процессыг үлэмж хурдасгахын хажуугаар хялбарчилж өгдөг ба түүнийг олон улсын хүрээлэн буй орчны эрх зүйн салбарт өргөнөөр хэрэглэдэг.¹⁸

- *Нэмэлт, өөрчлөлтийн Протокол* нь нэг буюу хэд хэдэн мөрдөгдөж байгаа гэрээнүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулах заалтыг өөртөө агуулдаг.¹⁹

- *Гэрээний Нэмэлт Протокол* нь өмнөх гэрээнд нэмэлт хийх зорилгоор батлагддаг.²⁰

- *Үйлийн Үгчилсэн Протокол* нь оролцогч талуудаас гаргасан санаачлагыг тэмдэглэхэд хэрэглэгддэг.

Үйлийн Үгчилсэн Протоколтой будилахад хүргэдэг олон улсын баримт бичиг бол модус вивенди юм. Соёрхон батлах шаардлагагүй, талуудын санаа бодлыг тусгадгаараа хоорондоо төсөөтэй. Хэлэлцэж буй асуудал нь сунжирсан, эсхүл түүнийг хэд хэдэн удаа хэлэлцэх шаардлагатай үед тухайн шатанд талуудын хүрсэн тохиролцоог тэмдэглэхэд модус вивендийг хэрэглэдэг.

Энхийг сахиулах ажиллагаа эхлүүлэх, конференц зохион байгуулах, зарим холбогдох хэлэлцээрийн хүрээнд үйл ажиллагааны чиг шугамыг тодорхойлох зэрэг асуудлаар НҮБ өөрийн гишүүн улсуудтайгаа ойлголцлын меморандум байгуулдаг. Үүнийг олон улсын байгууллагатай хамтран ажиллах эрхийн үндэс ч гэж практикт үздэг. Ойлголцлын Меморандум нь харьцангуй албан бус шинжтэй, соёрхон батлах шаардлагагүй дан баримт бичиг юм. Улс болоод олон улсын байгууллага түүнийг хуулийн үйлчлэлд оруулах эрх эдэлнэ.

Ишлэл, зүүлт

1. Харь хэлнээ хоёр өөр утга илэрхийлсэн, хоёр өөр үгийг монгол хэлнээ ижил агуулгатай нэг үг мэтээр буулгасан зэрэг зарим нэгэн ташаа зүйл байгаа нь судалгааны явцад ажиглагдаж байв. Иймд түүний оноосон гадаад нэрийг хөндөлгүйгээр зөвхөн утгын хувьд цэгцлэж, ялгааг нь гаргахыг хичээсэн болно.

2. 1990–ээд оны дунд үе хүртэл МОНЦАМЭ-гийн Гадаад мэдээний редакцияс Монголын төвийн бүх сонин, радио, ТВ-ийн гадаад мэдээг бэлтгэн өгч байсан нь маш зөв практик байжээ. Гэтэл өнөөдөр ТВ-үүд дор бүрнээ мэдээллээ хариуцдаг болж, юу дуртайгаа орчуулж, аль дуртайгаараа нэрлэж байгаа нь нэр томъёоны гажуудлыг үүсэхэд хүргэх хүчин зүйл болж байна.

3. Улсуудын хооронд гэрээ байгуулахад баримтлах журмыг агуулсан “Гэрээний эрх зүйн тухай Венийн Конвенц” 1969 онд батлагдаж, 1980 оны 1 дүгээр сарын 27-нд хүчин төгөлдөр болсон. Олон улсын байгууллага тал болон оролцсон гэрээнд баримтлах журмыг агуулсан “Улс ба олон улсын байгууллага, эсвэл олон улсын байгууллага хоорондын Гэрээний эрх зүйн тухай Венийн Конвенц”. Хуулийн дагуу хүчин төгөлдөр болоогүй байгаа.

4. 1946 оноос хойш Нарийн бичгийн дарга нарын газарт бүртгэгдсэн буюу хадгалагдсан бүх гэрээ болон олон улсын хэлэлцээрүүд НҮБ-ийн Гэрээний цувралд нийтлэгдсэн.

5. 1969 оны Конвенциор: “Гэрээ” гэж нэг буюу хоёр, эсхүл өөр хоорондоо холбоотой хэд хэдэн баримт бичигт агуулагдаж байгаа бөгөөд түүний тодорхой нэрээс хамаарахгүйгээр улсуудын хооронд бичгээр байгуулсан, олон улсын эрх зүйгээр зохицуулагдаж байгаа олон улсын хэлэлцээрийг хэлнэ, гэсэн бол 1986 оны конвенциор олон улсын байгууллага тал болон оролцсон хэлэлцээрийг олон улсын гэрээнд оруулснаар түүний тодорхойлолтыг өргөжүүлсэн.

6. 1969 оны Венийн Конвенци батлагдахаас өмнө хийгдэж байсан гэрээнүүд бүгд шахуу бичгэн хэлбэртэй байсан болно.

7. Гэрээний эрх зүйн тухай Венийн Конвенцийн 3 дугаар зүйл

8. Харь хэлнээ ганц оноосон нэрээр илэрхийлэгдэх үгийг манайд доод тал нь 2-4 холбоо үгээр илэрхийлдэг тал бий. Жишээлбэл Summit гэдэг үгийг “Дээд хэмжээний уулзалт”, “Өндөр хэмжээний хэлэлцээ” гэх мэт. Энд хэмнэлттэй байх зарчмын тухай ярьж байна. Гэхдээ нөгөө талаас үг хэмнэх нэрээр үндсэн утгыг алдагдуулахгүй байх нь чухал юм. Region гэдгийг газар зүйн утга илэрхийлэх хувьд нь “бүс” хэмээн нэрийдэх нь зөв болов уу хэмээн зохиогчийн зүгээс үзэж байна.

9. 1992 онд батлагдсан Биологийн төрөл зүйлийн тухай Конвенци, НҮБ-ийн Далайн эрх зүйн тухай Конвенци, 1969 оны Гэрээний эрх зүйн тухай Венийн Конвенци

10. 1951 оны Адил хөдөлмөр эрхэлж буй эрэгтэй, эмэгтэй ажилчдад тэгш шан хөлс олгох тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Конвенци, 1989 онд НҮБ-ын Ерөнхий Ассемблейн баталсан Хүүхдийн эрхийн тухай Конвенци

11. 1992 оны Риогийн Деклараци

12. 1948 оны Хүний Эрхийн Түгээмэл Деклараци

13. Хонконгийн асуудлаар Нэгдсэн Вант Улс ба Хятадын хооронд байгуулсан хамтарсан деклараци

14. Жинхэнэ гэрээний ард хавсралт хэлбэрээр орж, түүний зарим заалтыг тайлбарлах үүрэгтэй

15. 1957 онд Египетээс Суэцийн сувгийн асуудлаар гаргасан нэг талт деклараци ба түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой шийдвэрүүд нь олон улсын баримт бичгийн шинжийг өөртөө агуулж байна.

16. ХХ зууны томоохон аккордуудаас дурьдвал: Вьетнамын дайны галыг зогсоож, энх тайвныг тогтоох зорилгоор 1973 оны батлагдаж, мөн оныхоо 1 дүгээр сарын 17-нд хуулийн үйлчлэлд орсон Парисын Энхийн Аккорд, Израиль – Арабын орнуудын эвийн тохиролцоо болох Кемп Дэвидийн салангид аккорд

17. 1966 оны Иргэний ба улс төрийн эрхийн ковенантын албан бус протокол

18. 1985 оны Озоны давхаргыг хамгаалах тухай Венийн Конвенцийн 2 ба 8 дугаар зүйлд тулгуурлан байгуулсан Озоны Давхаргыг Задлах Бодисын Тухай 1987 оны Монреалын Протокол гэх мэт.

19. Хар тамхи, Мансууруулах бодисын Хэлэлцээр, Конвенци болон Протоколд нэмэлт оруулсан 1946 оны Протокол

20. Дүрвэгсдийн Эрх Зүйн Байдлын Тухай 1951 оны конвенц дэх дүрвэгсдийн статусын тухай асуудлаар батлагдсан 1967 оны Протокол